ШВЕД УЛСЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Захиргааны эрх зүйн маргаан)[1]

АЖИЛТАН ЦАЙНЫ ЦАГААРАА ҮДИЙН ХООЛ ИДЭХЭЭР ЯВАХ ЗАМДАА БЭРТСЭН ТОХИОЛДОЛД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛД ТООЦОГДОНО

САНАМЖ: *Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.*

Шүүхийн шийдвэрийн дугаар: 4076-25
Шүүхийн шийдвэрийн огноо: 2026 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр
Шийдвэрийн агуулга: Шведийн захиргааны хэргийн дээд шүүх давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, ажилтан цайны цагаараа үдийн хоол идэхээр явж байх замдаа бэртсэнийг үйлдвэрлэлийн осолд хамаарна гэж шийдвэрлэсэн.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Нэхэмжлэгч нь “А” сангийн удирдах зөвлөлийн даргаар ажилладаг байжээ. 2021 оны 12 дугаар сарын 19-ний өдөр тус сангийн цаашдын үйл ажиллагаа төлөвлөх арга хэмжээ (англ. *Planning day*) зохион байгуулагдсан бөгөөд нэхэмжлэгч болон бусад оролцогчид хурлын байранд цугларсан байна. Үдийн хоолны цаг болоход нэхэмжлэгч болон “А” сангийн бусад ажилчид хурлын байрнаас хол, хотын өөр хэсэгт байрлах ресторан руу хоол идэхээр явжээ. Гэтэл нэхэмжлэгч нь ресторан руу явж байх замдаа халтирч унасны улмаас мөрөндөө бэртэл авсан байна.

Нэхэмжлэгч нь энэхүү бэртлийн улмаас Шведийн Нийгмийн даатгалын тухай хуульд заасны дагуу тэтгэмж авах эрхтэй гэж үзэж Шведийн Нийгмийн даатгалын агентлаг (швед. *Försäkringskassan*)-т хүсэлт гаргасан байдаг. Тус агентлагаас “*Нэхэмжлэгчийн ресторан руу хооллохоор явсан үйлдэл нь түүний ажил үүрэгтэй холбоотой гэж үзэх боломжгүй*” гэж дүгнэсэн байна. Учир нь тэрээр үдийн хоолны цагаар тус ресторанаар тогтмол үйлчлүүлдэггүй байсан, түүнчлэн уг ресторан нь хурал болж буй газраас хол байрлалтай гэх дүгнэлтийг хийв. Мөн тус агентлаг “*Үдийн хоол идэх нь хурлын албан ёсны буюу заавал байх ёстой хэсэг биш*” гэж үзсэн бөгөөд албан ёсны ажилтай дүйцүүлэн үзэх боломжгүй гэж дүгнэжээ. Эдгээр үндэслэлүүдээр тус агентлаг нэхэмжлэгчийн тэтгэмж авах хүсэлтэд татгалзсан хариуг өгсөн байна.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

Өмнөх шатны шүүхээс: Нэхэмжлэгч тухайн шийдвэрийг эс зөвшөөрч мужийн захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хандсан боловч, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгожээ. Анхан шатны шүүх “Үдийн хоол нь “А” сангийн үйл ажиллагаа төлөвлөх арга

[1] Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: https://www.domstol.se/en/supreme-administrative-court/rulings-archive/case-no--4076-25/.

хэмжээний хөтөлбөрт заавал байх ёстой хэсэг гэдэг нь нотлогдоогүй, мөн үйлчлүүлэхээр явж байсан ресторан нь хурал болж байсан газраас хол байсан тул нэхэмжлэгч хувь хүнийхээ хувиар ресторанд бие даан очсон явдал байсан, түүнчлэн хоолны үнийг өөрийн хувийн зардлаар төлөхөөр байсан" зэрэг үндэслэлийг онцолжээ.

Харин мужийн захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх "*Нэхэмжлэгчийг хоол идэхээр явж байхдаа бэртсэн нь А сангийн бусад гишүүдтэй хамтаар ажлын цагт болсон, мөн үдийн хоол идэх нь А сангийн хурлын үйл ажиллагааны өдрийн нэг хэсэг байсан*" гэх үндэслэлээр үйлдвэрлэлийн осолд хамаарна гэж дүгнэжээ. Энэхүү дүгнэлтэд үндэслэн нэхэмжлэгчийг тэтгэмж авах эрхтэй гэх шийдвэрийг гаргасан бөгөөд хариуцагч Шведийн нийгмийн даатгалын агентлаг тус улсын дээд шүүхэд гомдол гаргасан байна.

Швед улсын Захиргааны хэргийн дээд шүүхээс давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг дараах үндэслэлүүдээр хэвээр үлдээж шийдвэрлэжээ. Үүнд:

1. Энэхүү маргаанд ажилтан цалин олгох ажлын цагаар үдийн хоол идэхээр ресторан руу явах замд түүнд учирсан гэмтэл нь үйлдвэрлэлийн осолд тооцогдох эсэх тухай асуудал байна.
2. Шведийн Нийгмийн даатгалын тухай хуулийн[2] 39 дүгээр бүлгийн 3 дугаар зүйлд "үйлдвэрлэлийн осол" гэдгийг ажил үүргээ гүйцэтгэх явцад гарсан осол болон бусад хортой нөлөөллийн улмаас учирсан гэмтэл гэж тодорхойлсон байна. Мөн 39 дүгээр бүлгийн 4 дүгээр зүйлд "гэмтэл"-д хүний бие махбодод учирсан гэмтэл хамаарахаар зохицуулжээ.
3. Үйлдвэрлэлийн ослын даатгалын үндсэн зорилго нь хөдөлмөрийн харилцааны хүрээнд бий болох онцгой эрсдэлээс ажилтныг хамгаалахад оршино. Иймд нэхэмжлэгч бэртсэн нь "үйлдвэрлэлийн осол" гэж үзэхийн тулд тухайн даатгуулагчийн хийж буй ажил болон бэртэж гэмтсэн үйл баримт хоорондтодорхой холбоо хамаарал байх шаардлагатай юм.
4. Даатгуулагч ажлын байран дээр ажил үүргээ гүйцэтгэж байх үед бий болсон үйлдвэрлэлийн ослын хувьд, ажил болон үйлдвэрлэлийн ослын хоорондох холбоо хамаарлыг тогтоохдоо өргөн хүрээтэй буюу уян хатан хандлага баримтлах ёстой. Өөрөөр хэлбэл, ажилтан осол гарах үед ажил олгогчийн өгсөн даалгаврыг гүйцэтгэж байсан эсхүл ажил олгогчийн ашиг сонирхлын төлөө тодорхой үйлдэл хийж байсан бол үйлдвэрлэлийн осол болон ажил хоорондын шалтгаант холбоо тогтоогдсон гэж үзнэ.
5. Тухайн тохиолдолд нэхэмжлэгчийн ресторан руу явж байсан идэвхтэй үйлдэл нь ажил олгогчийн зохион байгуулж буй арга хэмжээний үеэр, цалин олгох ажлын цагт, хамтран ажиллагчидтайгаа цуг явж байсан учраас ажил олгогчийн ашиг сонирхолд нийцүүлэн хийж байсан үйлдэл байсан гэж үзэх боломжтой.

---

[2] Швед Улсын Нийгмийн даатгалын тухай хууль (Socialförsäkringsbalken), https://www.riksdagen.se/sv/dokument-och-lagar/dokument/svensk-forfattningssamling/socialforsakringsbalk-2010110_sfs-2010-110/.

Иймд нэхэмжлэгчийн халтирч унасан нөхцөл байдал болон хийж буй ажлын хооронд Нийгмийн даатгалын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 3 дахь зүйлд заасан “үйлдвэрлэлийн осол” гэж тооцогдох хэмжээний холбоо хамаарал байсан гэж үзэх нь зүйтэй юм.

Эдгээр үндэслэлээр Захиргааны хэргийн дээд шүүх нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, А-ын үдийн хоол идэхээр явж байх үедээ халтирч унан бэртэл авсныг “үйлдвэрлэлийн осол”-д тооцно гэж шийдвэрлэжээ.

---o0o---